# ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Баруун-Урт 2024.06.24

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Төсөв /сая. төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Хэрэгжилт | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ** | | | | | | | | | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго-1.1: Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, чадавхыг сайжруулан, нийгмийн баталгааг хангах, хөрөнгө оруулалтыг шат дараатай шийдвэрлүүлэх** | | | | | | | | | |
| **Зорилт -1.1.1: Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, чадавхыг сайжруулан, нийгмийн баталгааг хангах** | | | | | | | | | |
| Гүйцэтгэлийн зорилт-1.1.1: | | Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, чадавхыг сайжруулан, нийгмийн баталгааг хангах | УТ ОНТ | Хөтөлбөрийн биелэлтийн хувь | 80 | 85 | 70 | Сүхбаатар аймгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн өнөөгийн байдлыг судалж, Сүхбаатар аймагт шаардлагатай хүний нөөцийг хангах зорилгоор 2 удаагийн хөдөлмөрийн яармаг арга хэмжээнд оролцож салбарын танилцуулгыг хийсэн. | **100** |
| 1 | Сүхбаатар аймгийн 2020-2028 оны хөгжлийн хэтийн зорилтын 2.4.1<br><br>АЗД-ын 2020-2024 оны ҮАХ-ын 2.1.6 | **Арга хэмжээ-1.1.1.1:** Эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж, арга зүйгээр хангах | | Төлөвлөгөө боловсруулсан байгууллагын хувь | 0 | 80 | 40 | Сүхбаатар аймгийн эрүүл мэндийн салбарын АНЭ, УАУНЭ, 2 Өрхийн эмнэлэг, 12 сумын Эрүүл мэндийн төвийн хүний нөөцийн өнөөгийн байдлыг судалж төлөвлөгөө гаргасан. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | | **Арга хэмжээ-1.1.1.2:** Эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын байрны урт богино хугацааны сургалтад хамруулах нэгдсэн төлөвлөгөө боловсруулах | | Төлөвлөгөө батлагдсан эсэх | 0 | 1 | 1 | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэлтэс нь ажлын байрны 3, танхимын 18, цахимаар 3 төрлийн сургалттай төлөвлөгөө боловсруулсан. Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтэс нь 7 төрлийн сургалт, Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтэс нь 2 төрлийн сургалт, Хяналт шалгалтын хэлтэс нь 4 төрлийн сургалтыг тус онд зохион байгуулахаар төлөвлөсөн. | 100 |
| 3 | | **Арга хэмжээ-1.1.1.3:** Сүхбаатар аймгаас анагаах ухааны чиглэлээр суралцаж байгаа оюутнуудын судалгааг гаргаж уулзалт зохион байгуулах | | Хийсэн уулзалтын тоо | 0 | 2 | 2 | Эрүүл мэндийн хөгжлийн төв, АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулиас зохион байгуулсан “Хөдөлмөрийн яармаг-2024” төгсөгчид болон суралцаж буй оюутнуудтай уулзах 2 удаагийн арга хэмжээнд оролцож Сүхбаатар аймгаас суралцаж буй оюутнуудын судалгааг гаргаж, уулзалт зохион байгуулсан. | 100 |
| **Зорилт-1.1.2: Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтыг шат дараалалтай шийдвэрлүүлэх зорилтын хүрээнд** | | | | | | | | | |
| **Гүйцэтгэлийн зорилт-1.2.2:** | | Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтыг шат дараалалтай шийдвэрлүүлэх | УТ, ОНТ, ЭМДС, Төсөл хөтөлбөр | Нийт санхүүжилтийн дүн | 6530,7 | 6314,1 | 435,0 | Эрүүл мэндийн салбарт шаардлагатай хөрөнгө оруулалтыг шат дараалалтай шийдвэрлүүлэн ажиллаж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1 ӨЭМТ-н барилгыг ашиглалтад хүлээн аваад байна. 2 сумын эмнэлгийн болон амбулаторийн барилгын ажил гэрээ байгуулах шатандаа явж байна. 2 сумын эмнэлгийн барилгын засварын зургийг хийлгэн, засварын ажил явагдаж байна. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 3 байгууллагад туулах чадвар сайтай автомашины парк шинэчлэл хийгдэж, УАУНЭ-т 15 нэр төрлийн тоног төхөөрөмж нийлүүлж хангалтыг сайжруулан ажиллаж байна. | **90** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | АЗД-ын 2020-2024 оны ҮАХ-ын 2.1.7.8 | **Арга хэмжээ 1.1.2.1:** Автомашины парк шинэчлэлтийг хийх | УТ, ОНТ 717,3 | Авто машины тоо | 14 | 5 | 3 | Орон нутгийн 435,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ЭМГ, Дарьганга, Уулбаян сумдын эрүүл мэндийн төвүүдэд туулах чадвар сайтай Ланд крузер 76 маркийн автомашины парк шинэчлэлт хийгдсэн. | 100 |
| 2 | АЗДМХ 2.1.4, Сүхбаатар аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө | **Арга хэмжээ 1.1.2.2:** Уламжлалтын нэгдсэн эмнэлэгт шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах | ОНТ-н 40,0 | Хангагдсан эсэх | 1 | 1 | 1 | Орон нутгийн төсвийн 32,3 сая төгрөгийн 15 нэр төрлийн тоног төхөөрөмжийг УАУНЭ-т нийлүүлсэн. | 100 |
| 3 | АЗДМХ 2.1.7 | **Арга хэмжээ 1.1.2.3:** Энхлэн Ачтан өрхийн эрүүл мэндийн төвийн шинэ барилгыг ашиглалтад хүлээн авах | ОНТХО-н 500,0 | Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь | 95 | 100 | 100 | 2024 оны 3-р сард ашиглалтад хүлээн авч үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна. | 100 |
| 4 | АЗДМХ 2.1.7, Сүхбаатар аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө | **Арга хэмжээ 1.1.2.4:** Түмэнцогт суманд шинээр баригдах 17 ортой эрүүл мэндийн төвийн барилгын угсралтын ажлыг эхлүүлэн хяналт хийх | УТХО-н 3430,7 | Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь | 0 | 30 | - | Улсын төсвийн 3430,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар баригдах 17 ортой эмнэлгийн барилгын гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар дээр зарлагдаж гүйцэтгэгч компани нь шалгарсан. Гэрээ байгуулах шатанд явж байна. | 50 |
| 5 | АЗДМХ 2.1.7, Сүхбаатар аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө | **Арга хэмжээ 1.1.2.5:** Халзан суманд шинээр баригдах эрүүл мэндийн төвийн амбулаторийн | УТХО-н 1766,1 | Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь | 0 | 30 | - | Улсын төсвийн 1766,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар баригдах амбулаторийн барилгын гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар дээр зарлагдаж гүйцэтгэгч компани нь шалгарч гэрээ байгуулагдсан. | 50 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | барилгын угсралтын ажлыг эхлүүлэн хяналт хийх | | | | | | | |
| 6 | АЗДМХ 2.1.7, Сүхбаатар аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө | **Арга хэмжээ 1.1.2.6:** Онгон сумын эрүүл мэндийн төвийн барилгын их засварын ажлыг эхлүүлэх | ОНТХ О-н 475,0 | Барилгын засварын ажлын гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 90 | Гүйцэтгэгч компани шалгаран барилгын засварын ажлыг эхлүүлсэн. Гүйцэтгэл 90 хувьтай засварын ажил хийгдэж байна. | 100 |
| 7 | АЗДМХ 2.1.4, Сүхбаатар аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө | **Арга хэмжээ 1.1.2.7:** Асгат сумын эрүүл мэндийн төвийн барилгын засварын зураг төсвийг хийлгэх | | Зураг төсөв хийгдсэн эсэх. | 0 | 1 | 1 | Зураг төсвийг захиалга өгөн хийлгэсэн | 100 |
| 8 | Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө | **Арга хэмжээ 1.1.2.8:** Эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийг шалгалт тохируулга баталгаажилтад хамруулна | Улсын төсөв | Хамрагдсан ЭМБ-ын тоо | 0 | 16 | - | 2024 онд шалгалт тохируулгад хамруулах тоног төхөөрөмжийн судалгааг АНЭ, УАУНЭ, 12 сумын ЭМТ, 2 өрхөөс авсан. Тус оны 10 сард ЭЭХХЗГ-аас баг ирж тоног төхөөрөмжүүдийг шалгалт тохируулгад хамруулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | 50 |
| **Стратегийн төлөвлөгөөний Зорилго-1.2: Эрүүл мэндийн салбарын хууль эрх зүй, ёс зүй, тусгай зөвшөөрөл, ил тод байдлыг ханган ажиллах** | | | | | | | | | |
| **Зорилт-1.2.1: Эрүүл мэндийн салбарын хууль эрх зүй, ёс зүй, тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг сайжруулах** | | | | | | | | | |
| 1 | Эрүүл мэндийн тухай хуулийн 26 дугаар зүйл | **Арга хэмжээ 1.2.1.1:** Эмч эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо байгуулж үйл | | Ёс зүйн салбар хороо байгуулагдсан эсэх | 0 | 1 | | Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороонд шалгаруулж авах сонгон шалгаруулалтын зарыг мэдээллийн хэрэгслээр нийтэд түгээсэн. Одоогоор 3 хүнээс материал ирээд байна. | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажиллагааг тогтмолжуулах | | | | | | | |
| 2 | Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйл | **Арга хэмжээ 1.2.1.2:** Тусгай зөвшөөрөл хүсэгчийн эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, сэргээх, гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах комиссын хурлыг тухай бүр зохион байгуулж, ээлжит бус хуралдааныг зарлах | | Зохион байгуулсан хурлын тоо | 3 | Тухай бүр | 4 | Тусгай зөвшөөрлийн комисс 2024 оны 2 дугаар улирлын байдлаар 4 удаа хуралдаж 12 байгууллагын хугацааг сунгаж, 1 байгууллагад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгож, шинээр зөвшөөрөл олгох 4 байгууллагад шинжээч томилсон байна. Мөн ЭМС-н 2023 оны 412 дугаар тушаалын дагуу шинжээч томилох зарыг нийтэд түгээж 2 шинжээч томилсон. Одоогоор эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх байгууллагад тусгай зөвшөөрөл олгох комисс 3 шинжээчтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. | 100 |
| 3 | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл | **Арга хэмжээ 1.2.1.3:** Өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж ил тод байдлыг хангах | | Хугацаанд нь шийдвэрлэсэн өргөдөл гомдлын хувь | 90 | 95 | 75 | 2024 оны 2 дугаар улирлын байдлаар 4 өргөдөл гомдол, ирснээс 50%-ийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн. 1 гомдлын хуулийн хугацааг сунгасан. 2 гомдлын шийдвэрлэх хугацаа болоогүй байна. Үүнээс: - Эмч, эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлагатай холбоотой 2/50%, Иргэний эрүүл аюулгүй орчинд амьдрахтай холбоотой -2/50%.<br>Өргөдөл, гомдлын 1 дүгээр улирлын мэдээг байгууллагын вэб сайтад байршуулсан. | 90 |
| 4 | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл | **Арга хэмжээ 1.2.1.4:** Байгууллагын ил тод байдлыг хангаж | | Шилэн дансанд байршуулсан | 80,7 | 100 | 100 | Шилэн дансны цахим хаягаар байгууллагын төсөв санхүү, хөрөнгө оруулалтын мэдээллийг тухай бүр нийт 80 мэдээлэл байршуулан ил тод нээлттэй мэдээлсэн. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | шилэн дансны мэдээллийг тогтмол байршуулах | | мэдээллийн хувь | | | | | |
| 5 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5.5.1 | **Арга хэмжээ 1.2.1.5:** Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах | 0.5 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | 100 | 70 | БНШК-ыг шинэчилж, 1 удаа хуралдаж Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх 15 заалт бүхий төлөвлөгөө, БНШК-ын 2024 оны төлөвлөгөө, нөхөн бүрдүүлэлтийн төлөвлөгөө гарган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу 5 хэлтсээс нийт 36 хадгаламжийн нэгжийг хүлээн аваад байна. | 90 |
| 6 | Монгол бичгийн үндэсний хөтөлбөр | **Арга хэмжээ 1.2.1.6:** Албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр хөтлөн явуулах | 0.1 | Хос бичгээр хөтөлсөн баримт бичгийн хувь | 5 | 60 | 30 | Байгууллагын Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байна. Албан бичгийг хос бичгээр хөтлөн явуулж эхэлж байна. Архив, бичиг хэргийн ажилтан Монгол бичгийн цахим сургалтын 2-р шатад хамрагдаж байна. | 70 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.3**: Хүн амын дунд зонхилон тохиолдож буй халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгоо шинжилгээний хамрагдалтыг нэмэгдүүлнэ | | | | | | | | | |
| **Зорилт 1.3.1** Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бэхжүүлэх замаар иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг оношилгоо шинжилгээнд жил бүр 30-аас доошгүй хувийг хамруулна | | | | | | | | | |
| **Гүйцэтгэлийн зорилт-1.3.1:** | | Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бэхжүүлэх замаар иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг оношилгоо | УТ, ОНТ | Халдварт бус өвчний эрт илрүүлгийн хамрагдалтын хувь | 69.2% | 70% | 24% | Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бэхжүүлэх замаар иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг оношилгоо шинжилгээнд хамруулж байна. 2024 оны 5 сарын байдлаар Халдварт бус өвчний Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг үзлэгт 42258/7127/16,8%, Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 28479/6020/21,1% хамрагдсан байна. Хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 13109/4367/33,3% байна. | **70** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | шинжилгээнд жил бүр 30-аас доошгүй хувийг хамруулна | | | | | | Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 4609/1182/25,6% байна | |
| 1 | МУ-ын Эрүүл мэндийн сайд Сүхбаатар аймгийн засаг засаг даргатай байгуулсан 3.2 | **Арга хэмжээ 1.3.1.1** Эрт илрүүлгийн үзлэг шинжилгээний хамралтыг нэмэгдүүлэх | | 0-17 насны хүүхдийн хамрагдалтын хувь | 23736 /19599/ 82.5% | 23736/21282/ 90% | 82.5% | 0-17 насны хүүхдийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 23736/19599/82,5%-н хамрагдалтай байна. | 100 |
| | | | | 18-аас дээш насны иргэдийн хамралтын хувь | 41421 /8914/ 21.5% | 41421/21500/ 50% | 50 | 18-аас дээш насны иргэдийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 41565/11814/28,4%-н хамрагдалтай байна. | |
| 2 | МУ-ын Эрүүл мэндийн сайд Сүхбаатар аймгийн засаг засаг даргатай байгуулсан 3.2 | **Арга хэмжээ 1.3.1.2** Артерийн даралт ихсэх өвчин, чихрийн шижин хэв шинж -2, хөхний өмөн, умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ | | Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хувь | 41565 /17811/ 43% | 54.1 % | 16.8% | Эхний 5 сарын байдлаар Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 42258/7127/16,8% | 70 |
| | | | | Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хувь | 25463 /17811/ 70% | 88,3% | 21.1% | Эхний 5 сарын байдлаар Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 28479/6020/21,1% | |
| | | | | Хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хувь | 11058 | 11890 | 4367 | Эхний 5 сарын байдлаар Хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал хувь 13109/4367/33,3% | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хувь | 4519/ 3120/ 69 % | 71.7% | 25.6% | Эхний 5 сарын байдлаар Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 4609/1182/25,6% байна. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго-1.4: Хүн амд үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, эрүүл мэндийн дэмжих арга хэмжээг хэрэгжүүлнэ.** | | | | | | | | | |
| **Зорилт-1.4.1:Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллана** | | | | | | | | | |
| **Гүйцэтгэлийн зорилт-1.4.1:** | | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллана | | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж хувь | 50.8 | 80 | 70 | 2024 онд 13 арга хэмжээг 19 эрүүл мэндийн байгууллага хэрэгжүүлэн ажиллаж байна. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж хувь 70% | **90** |
| 1 | Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө 1.5 | **Арга хэмжээ 1.4.1.1:** ‘’Хавдрын эсрэг арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө’’-ний хэрэгжилтийг хангаж ажиллах /ЭМС-ын 2021 А/360 2021-2024 он / /ЭМС-ын А/360 тушаал | 1.0 | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 85 | 87 | 60 | 2024 онд Хавдрын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөг 4 зорилго, 12 заалтын хүрээнд боловсруулан батлуулсан.<br><br>**Хийгдсэн томоохон ажил:**<br><br>1.Сүхбаатар Аймгийн нэгдсэн эмнэлэгт Хавдар судлалын Үндэсний төвийн эмэгтэйчүүдийн мэс заслын эмч нар ирж орон нутагт мэс засал хийж, эх барих эмэгтэйчүүдийн эмч нарт ажлын байрны сургалт зохион байгуулсан. Нийт 8 эмч мэргэжилтэн хамрагдсан.<br><br>2. Асгат, Эрдэнэцагаан, Сүхбаатар, Дарьганга, Онгон, Наран сумдын нийт 120 эмч эмнэлгийн | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | мэргэжилтэнд ХБӨ-өөс урьдчилан сэргийлэх танхимын сургалтыг зохион байгуулсан.<br><br>3.“Дэлхийн тамхигүй өдрийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд” Тамхигүй орчин-Бидний ирээдүй” гар зургийн уралдаан зохион байгуулж. Эхний 3 байрыг шалгаруулж шагнан урамшуулсан. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн цахим хуудсанд байршуулсан мэдээ мэдээллийг өрх, сумын эрүүл мэндийн төвүүдийн цахим хуудсанд тогтмол байршуулан ажиллаж байна.<br><br>Хавдрын нас баралт өмнөх оны мөн үеэс 2,7 промилиор өссөн, хорт хавдрын өвчлөл өмнөх оны мөн үеэс 1000 хүн амд 0,8 промиль буюу 1,2 промилиор буурсан үзүүлэлттэй байна. | |
| 2 | Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө 1.4 | **Арга хэмжээ 1.4.1.2:**<br>“Эрүүл идэвхтэй амьдрал” 2021-2024 оны арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах /ЭМС-ын А/780 тушаал/ | 3.0 | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 80 | 85 | 77 | 2024 онд Эрүүл идэвхтэй амьдрал арга хэмжээний төлөвлөгөөг 5 зорилго, 24 заалтын хүрээнд боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>**Хийгдсэн томоохон ажил**<br>1.**Энэ жилдээ-Эрүүл жиндээ** 2 аяны хүрээнд Бүх нийтийн кросс гүйлтийг 12 сумын ЭМТөвүүд орон нутгийн ЗДТГ болон албан байгууллага, ААНэгжүүдтэй хамтран 2024 оны 4 дүгээр сарын 13-ны өдрөөс эхэлж найман 7 хоногийн турш 53 байгууллагатай хамтран зохион байгуулав.. Арга хэмжээнд давхардсан тоогоор 7000 гаруй аж ахуйн нэгж, албан байгууллагын ажилтан албан хаагчид, иргэд хамрагдаад байна.<br>2.Сар бүр эхийн сүүгээр хооллолтын мэдээг сум, өрхийн ЭМТ-өөс авч нэгтгэсэн. Үүний үр дүнд эхийн сүүгээр дагнан хооллолт 88.1%, 06-23 сартай хүүхдийн эхийн сүүгээр хооллолт 55.9%-тай байна. Эхийн сүүгээр хооллолтын ач | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | холбогдол, ажлын байранд эхийн сүүгээр хооллолтын булан ажиллуулах уриалга гарган Уртын гэгээ ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан 2 төрлийн мэдээллийг 4 самбарт байршуулсан. ЭМТөвөөс эхний 5 сарын байдлаар 0-5 насны 526 хүүхэд, давхардсан тоогоор жирэмсэн 462, хөхүүл 197 эхэд хооллолтын зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.<br>3.Хоол хүнс үйлдвэрлэгчид, Ахмад настан, Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд, бага насны хүүхдэд цахим болон танхимын сургалтыг зохион байгуулж зөвлөгөө мэдээлэл хүргэсэн.<br>4.НҮБ-ын хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр өндөр тунт А, Д аминдэм, ОНБТБэлдмэлийг 0-59 сартай 10600 хүүхдэд түгээж эцэг эх асран хамгаалагчид хэрхэн уух А, Д аминдэм уухын ач холбогдлын сургалт мэдээлэл, зөвлөгөөг үе шаттайгаар өгч байна.<br>5.Эрүүл зүрхний төлөө давсаа багасгацгаая уриатайгаар давсны хэрэглээг бууруулах мэдээлэл сурталчилгааны 7 хоногийн хугацаанд нийтийн хоол үйлдвэрлэлийн 19 газарт давсны хэрэглээг багасгах мэдээлэл зөвлөмжийг өгч 33 тогоочид давсны хэрэглээг бууруулах хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ түүний ач холбогдол, 18 ААНэгж, албан байгууллага 374 иргэд, 23 бүлгийн 690 гаран бага ангийн сурагчдад давс багатай хоол хүнс хэрэглэх, давсны хор уршиг, давсалсан бүтээгдэхүүнээс татгалзах уриалга, зөвлөмж,сургалтыг зохион байгуулан ажилласан. | |
| 3 | Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө 2.2 | | 10.0 | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 80 | 85 | 75 | 2022-2025 онд хэрэгжих Элэг бүтэн Монгол арга хэмжээний 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан.<br>**Хийгдсэн томоохон ажлууд:** | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **Арга хэмжээ 1.4.1.3:** Элэг бүтэн Монгол арга хэмжээний 2022-2025 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллах /ЭМС-ын А/577 тушаал/ | | | | | | 1.“**Гепатитгүй Сүхбаатарчууд төсөл”**-н хүрээнд цусаар дамжих халдвар, гепатит В вирусийн насанд хүрэгчдийн дархлаажуулалтын талаар мэдлэг ойлголтыг сайжруулах зорилгоор элэгний хөтөч, эрүүл мэндийн эмч, эмнэлгийн ажилчид, сумдын засаг дарга, багийн дарга, үсчин, маникюр зэрэг гоо заслын үйлчилгээ үзүүлэгч 333 хүнийг чадавхжуулах танхимын сургалтыг зохион байгуулсан. Мөн элэгний хавдар, хатууралтай 70 иргэдэд зөвлөгөө өгч, үзлэг хийн ажилласан. Эмч эмнэлгийн ажилчдад 28 ширхэг ном, иргэдэд 5 төрлийн 534 ширхэг гарын авлагыг тараасан.<br><br>Аймгийн хэмжээнд гепатит В вирусийн эсрэг 500 хүн тун насанд хүрэгчдийн вакциныг татан авч, эрүүл мэндийн төвүүдэд хуваарилан нийт 188 иргэнийг өөрийн хүсэлтээр /1, 2-р тун буюу 340 хүн тун/ дархлаажуулалтад хамруулан ажиллаж байна. Дархлаажуулалтын дараах урвал хүндрэл илрээгүй.<br><br>-Гепатитгүй Монголчууд төслийн хүрээнд 13 сумын Ерөнхий Боловсролын болон Бүрэн дунд боловсролын сургуулийн 9-12 дугаар ангийн сурагчид, Мэргэжлийн боловсролын сургуулийн оюутан сурагчдыг элэгний В,С вирус илрүүлэх шинжилгээнд хамруулсан. Нийт 3126/2566/82,0% хүүхэд хамрагдсанаас түргэвчилсэн шинжилгээгээр В вирус-7, С вирус-6 тус тус эерэг илэрсэн байна. В вирус халдвартай нэг хүүхэд эм ууж байгаа бөгөөд бусад 12 хүүхдийг ӨЭМТ-ийн эмчийн хяналтад шилжүүлж, эцэг эх асран хамгаалагчид мэдээлсэн. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | **Сургалт сурталчилгаа:**<br><br>ХСҮТ-с зохион байгуулсан Гепатитын вирусийн халдварын, тандалт, урьдчилан сэргийлэлт, илрүүлэг, оношилгоо,эмчилгээ, хяналт сэдэвт цахим сургалтад аймгийн нэгдсэн эмнэлэг, өрх, сумын эрүүл мэндийн төвүүдийн 20 эмч мэргэжилтнүүдийг хамруулсан. Эрүүл мэндийн газрын цахим хуудсанд тогтмол мэдээ мэдээллийг байршуулан ажиллаж байна. | |
| 4 | Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө 1.6 | **Арга хэмжээ 1.4.1.4:**<br>“Харшлаас сэргийлэх” арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах /ЭМС-ын А/816 тушаал/ | 5.0 | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 85 | 87 | 65 | 2024 онд “Харшлаас сэргийлэх” арга хэмжээний төлөвлөгөөг 4 зорилго, 12 заалтын хүрээнд боловсруулан батлуулсан.<br>**Хийгдсэн томоохон ажлууд:**<br><br>1. “Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд” Эрүүл мэндийн салбарын хэмжээнд 456 ширхэг хайлаас тарьсан.<br>2. Арьс харшлын эмчид нийт 3376 иргэн үзүүлсэн. Үүнээс харшилд 137 үзүүлсэн.<br>3. 2024 оны 6 сарын 1-с эхлэн харшлын сувилагчтай болж харшлын сорилыг хийж эхэлсэн.<br>**Цахимд байршуулсан мэдээлэл:**<br>Ерөнхий боловсролын сургуулийн 153 хүүхдэд ХАРШЛЫН ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЬЕ уриа доор сургалт зохион байгуулан, 2 төрлийн 486 ширхэг гарын авлага тараан ажилласан. Бяцхан эмч клубийн 11 хүүхдэд харшил гэж юу вэ сэдвээр мэдээлэл өгч ажилласан. ЕБС-ийн эрүүл мэндийн хичээлийн багш нарт харшлын өвчнөөс сэргийлэх сургалтыг 3 дугаар улиралд зохион байгуулахаар төлөвлөж байна.<br>-Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн цахим хуудсанд байршуулсан 2 видео 9 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | төрлийн зөвлөмжийг аймгийн нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн цахим хуудсаар дамжуулан иргэдэд тогтмол хүргэж нийт хандалт 3500 байна. Мөн 400 ширхэг гарын авлага тараан ажилласан. | |
| 5 | Эрүүл мэндийн салбарын 2022 - 2025 оны стратеги төлөвлөгөө 1.7 | **Арга хэмжээ 1.4.1.5:** “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээ төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах /ЭМС-ын А/559 тушаал/ | 5.0 | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 80 | 85 | 60 | “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний 2024 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.<br>**Хийгдсэн томоохон ажлууд:**<br>1. АНЭ-ийн мэс засал-Урологийн кабинет нь 7 хоногийн мягмар, пүрэв гарагуудад ажиллаж байна. Урологийн эмч давхардсан тоогоор нийт 207 иргэнд үзлэг, оношилгоо хийсэн байна.<br>2. “Малчин таны гарын авлага”-г хэвлэн 12 сум, 2 өрхийн эрүүл мэндийн төвүүдээр дамжуулан отроор яваа иргэд болон алслагдсан малчин иргэдэд 2500 ширхгийг олшруулан хүргэн ажилласан байна.<br>3. Өсвөр үеийн хүүхдүүдийн тулгамдсан асуудлыг сонсох үе тэнгийн сургагч багш бэлтгэх үйл ажиллагаа явагдаж “Эрүүл мэндийн хороо”, “Бяцхан эмч “ зэрэг 6-8 дугаар ангийн нийт 20 гишүүнтэй өсвөр үеийн хүүхдийн клубийг ажиллуулж байна. Үе тэнгийн сургагч багш нараар дамжуулан нөхөн үржихүйн эрүүл мэнд сэдвээр 50 сурагчдад танхимын сургалт зохион байгуулсан.<br>4. Эрүүл мэндийн газар, АНЭ, ӨЭМТ, Хувийн хэвшлийн эмнэлгүүдтэй хамтран Нийгмийн эрүүл мэндийг дэмжих нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулсан. Өдөрлөгөөр хүрэлцэн ирсэн өсвөр насны охид хөвгүүдэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр гарын авлага | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | боловсруулан нийт 170 ширхгийг тараан ажилласан.<br>5. Засгийн газрын мөрийн хөтөлбөр, Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хангах зорилгоор Эмнэлгийн тусламж үйлчилгээг “Явуулын хэлбэрээр үзүүлэх “ тухай удирдамж гаргаж батлуулсан. Үүний хүрээнд Түвшинширээ, Дарьганга, Онгон, Наран, Сүхбаатар, Түмэнцогт суманд үзлэг зохион байгуулсан. ХДХВ/ДОХ/БЗДХ –ын шинжилгээнд зорилтот бүлгийн нийт 7917 иргэн хамрагдахаас 2331 хамрагдаж үзлэг 29% -тай байна. | |
| 6 | Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө 1.11 | **Арга хэмжээ 1.4.1.6:**<br>“Орчны эрүүл мэнд хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” хэрэгжүүлэн ажиллах /ЭМС-ын А/349 тушаал/ | 5.0 | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 90 | 90 | 80 | Орчны эрүүл мэнд хөтөлбөрийн 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 7 зорилт, 23 арга хэмжээний хүрээнд боловсруулан батлуулсан.<br>**Хийгдсэн томоохон ажил:**<br>1. Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах тухай ЭМС-ын 2023 оны 11 дүгээр сарын “Тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангаж ажиллах тухай” 07 албан даалгаврыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад танилцуулан үүрэг чиглэл өгч, 11 үйл ажиллагаа бүхий төлөвлөгөөг батлуулан ажиллаж, хэрэгжилт 100 хувь хангагдсан.<br><br>2. Үйл явдлын талаар хэлэлцэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох зорилгоор Сүхбаатар аймгийн Дарьганга суманд үүссэн угаарын хийн хордлоготой холбоотой асуудлын талаар ЭМЯ, НЭМҮТ, ЭМГ, АОК, СОК, СЭМТөвийн нийт 6 байгууллагын, 19 хүний бүрэлдэхүүнтэй цахим | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хэлэлцүүлэг хийж, эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээг хийхэд "БАГА" эрсдэлтэй гэж дүгнэгдсэн. Үүний дагуу тайван цагийн горимоор холбогдох эрх зүйн баримт бичгийн хүрээнд ажилласан.<br><br>3. БОАЖГ, ЭМЯ, НЭМҮТ, БЕГ-ууд хамтран "ЭРҮҮЛ ОРЧИН – ЭРҮҮЛ ХҮҮХЭД" нөлөөллийн ажлыг өсвөрийн парламент 2023 хөтөлбөрийн гишүүдээр төлөөлүүлж хүүхэд, өсвөр насныханд орчны эрүүл мэндийн талаар мэдлэг мэдээлэл олгох, байгаль орчинд ээлтэй амьдралын хэв маяг, дадал зуршилд уриалах парламентын боловсролын талаар мэдлэг мэдээлэл өгөх зорилгоор Баруун-Урт сумын ерөнхий боловсролын дөрвөн сургуулийн ус, ариун цэвэр, эрүүл ахуйн үнэлгээг хийхэд, дөрвөн сургууль "Дунд" үнэлэгдсэн байна.<br><br>4. "УС БА ЭНХТАЙВАН" уриа дор Сүхбаатар аймгийн хэмжээнд урлагаар дамжуулан усны нөөцийг үр ашигтай зарцуулах, усыг хайрлан хамгаалахад иргэн бүрийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор СӨБ, МСҮТ, ЕБС-ийн нийт 635 сурагч, 360 эмч, эмнэлгийн ажилчид, 1250 иргэнд 3 сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулж, 16 эрүүл мэндийн байгууллага Усны мандала хаштагыг ашиглан энэхүү давалгаанд нэгдэж, UN-Water@Worldwaterday2024 цахим хуудсандаа ундны усны ач холбогдол, давалгаанд нэгдсэн иргэдэд чиглэсэн зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Нийт 7 төрлийн (шторк-1, постер-6), 1430 ширхэг гарын авлага, 6 төрлийн мэдээлэл байршуулсан, хандалт 15000 гаруй байна.<br><br>5. "Шар усны үер, үерийн аюулаас урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай" 01 албан даалгаврын хүрээнд Шар усны | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | үерийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг Аймгийн засаг даргын 2024 оны А/108 захирамжаар томилогдсон нийт 7 байгууллагын, 14 хүний бүрэлдэхүүнтэй баг эрсдэлийн үнэлгээг хийхэд, “МАШ ИХ” эрсдэлтэй гэж дүгнэгдсэн. Сумдын засаг дарга нарт болон бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад 1 удаа сэг зэм устгал, үерийн дараах зөвлөмжийг хүргүүлж, эрүүл мэндийн байгууллагууд пэйж хуудсандаа нийт 10 төрлийн (шторк-1, постер-9), 4 мэдээлэл байршуулсан, хандалт 8500 гаруй байна.<br><br>6. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, зөвлөгөө мэдээлэл өгөх ур чадварт сургах, оношилгоо эмчилгээний стандарт зааврын хэрэгжилтийг хангуулах, яаралтай тусламж үзүүлэх чадавхыг бэхжүүлэх зорилгоор “Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх сургалт”-ыг НЭМҮТ-ийн ШУНХСАлбатай хамтран, 16 эрүүл мэндийн байгууллагын нийт 92 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд цахим сургалтыг зохион байгуулсан.<br><br>7. БОАЖГ, ЭМЯ, НЭМҮТ, БЕГ-ууд хамтран “**ЭРҮҮЛ ОРЧИН – ЭРҮҮЛ ХҮҮХЭД**” нөлөөллийн ажлыг өсвөрийн парламент 2023 хөтөлбөрийн гишүүдээр төлөөлүүлж хүүхэд, өсвөр насныханд орчны эрүүл мэндийн талаар мэдлэг мэдээлэл олгох, байгаль орчинд ээлтэй амьдралын хэв маяг, дадал зуршилд уриалах парламентын боловсролын талаар мэдлэг мэдээлэл өгөх зорилгоор Баруун-Урт сумын ерөнхий боловсролын 4 сургуулийн ус, ариун цэвэр, эрүүл ахуйн үнэлгээг хийхэд. 4 сургууль “Дунд” үнэлэгдэж, тайланг БЕГ, НЭМҮТөвд танилцуулсан. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө 2.1 | **Арга хэмжээ 1.4.1.7:** “Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээний 2022-2025 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө” -ний хэрэгжилтийг ханган ажиллах /ЭМС-ын А/528/ | 10.0 | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 80 | 85 | 60 | Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээний 8 зорилт 55 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна.Эхний хагас жилийн байдлаар дараах томоохон ажлууд хэрэгжиж байна.<br>1. Засгийн газрын 2024 оны 472 дугаар тогтоолын дагуу Хүний папиллома вирусийн эсрэг вакциныг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд аймгийн хэмжээнд 4 (НЭМТ дарга, Дархлаажуулалт, хүүхэд, сургалт сурталчилгаа хариуцсан эмч) сургагч багш бэлтгэгдэж эхний хагас жилийн байдлаар бэлтгэл ажлыг хангахаар 12 сумын эрүүл мэндийн төвийн 300 эмч эмнэлгийн мэргэжилтэнд танхимын сургалт зохион байгуулж, дархлаажуулалтын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийсэн. Мөн АНЭ-д Хүний папиллома вирусийн 16, 18 хэв шинжийг тодорхойлох урвалж оношлуурыг захиалан бэлтгэлийг хангасан./Дархлаажуулалт/<br>2. Глобал сангийн дэмжлэгтэй Монгол улсад ДОХ, Сүрьеэ өвчнөөс сэргийлэх түүнийг эмчлэх үндэсний тогтолцоог бэхжүүлэх, дэмжлэг үзүүлэх төслийн хүрээнд ЭМГ-ын НЭМТ дарга, МСЭМХ-ны Сүхбаатар аймаг дахь тэргүүн, АНЭ-ийн сүрьеэгийн диспансер эмч нарын хамтарсан баг 12 сумын эрүүл мэндийн төвийн 184 эмч эмнэлгийн мэргэжилтэнд танхимын сургалт зохион байгуулж, дэмжлэгт хяналт хийж ажилласан.<br>3. ДЭМБ, ЭМЯ, ХӨСҮТ-ийн хамтарсан ОЭТН-ын халдварын тохиолдлын тандалт судалгаа хийгдсэн. Мөн Бичил | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | биетний тэсвэржилтийн эсрэг хариу арга хэмжээ, эмнэлэгт суурилсан тандалт хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх 2 өдрийн сургалтыг зохион байгуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>4. Засгийн газрын мөрийн хөтөлбөр, Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хангах зорилгоор Эмнэлгийн тусламж үйлчилгээг “Явуулын хэлбэрээр үзүүлэх “ тухай удирдамж гаргаж батлуулсан. Үүний хүрээнд Түвшинширээ, Дарьганга, Онгон, Наран, Сүхбаатар, Түмэнцогт суманд үзлэг зохион байгуулсан. ХДХВ/ДОХ/БЗДХ –ын шинжилгээнд зорилтот бүлгийн нийт 7917 иргэн хамрагдахаас 2331 хамрагдаж үзлэг 29% -тай байна. | |
| 8 | Сүхбаатар аймгийн хөгжлийн хэтийн зорилт 2020-2028 | **Арга хэмжээ 1.4.1.8:**<br>Хүүхдийн товлолын дархлаажуулалт, иргэдийн сайн дурын дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлж, дархлаажуулалтын үйл ажиллагаанд тавих хяналтыг тогтмолжуулж, дархлаажуулалт хариуцсан эмнэлгийн | 32.0 | Товлолт дархлаажуулалт-ын хамралтын хувь | 98% | 99% | 98.7 | Заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолын дагуу 0-15 хүртэлх насны хүүхдийг, 12 төрлийн халдварт өвчний эсрэг, 8 төрлийн вакцинаар товын дагуу дархлаажуулах үйл ажиллагааг аймгийн хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна.<br>ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын албанаас 2024 оны 5 дугаар сарын байдлаар 94.0 сая төгрөгийн үнэ бүхий 15 нэр төрлийн вакцин, дагалдах уусмал, 6 нэр төрлийн тарилгын тоног төхөөрөмжийн татан авалтыг хийж, дархлаажуулалтын 15 нэгжийг вакцин дагалдах хэрэгслээр тасралтгүй, стандартын дагуу ханган нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна. Дархлаажуулалтын хамралт 98.7 хувьтай байна. | 90 |
| | | | | Сайн дурын дархлаажуулал-тад хамрагдсан иргэдийн тоо Хяналтын тоо | 500 | 700 | 188 | | |
| | | | | Хяналтын тоо | 2 | 4 | 1 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах | | Сургалтын тоо | 2 | 4 | 3 | Аймгийн хэмжээнд гепатит В вирусийн эсрэг 500 хүн тун насанд хүрэгчдийн вакциныг татан авч, эрүүл мэндийн төвүүдэд хуваарилан нийт 188 иргэнийг өөрийн хүсэлтээр вакцинжуулалтад 1, 2-р тун буюу 340 хүн тун вакцинд хамруулан ажиллаж байна. Дархлаажуулалтын дараах урвал хүндрэл илрээгүй.<br>Үндэсний товлолын дагуу хүний папиллома вирусийн эсрэг вакцинаар 11 настай хүүхдийг дархлаажуулах бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах аргазүйн сургалтын сургагч багшаар аймгийн хэмжээнд 4 эмч бэлтгэгдсэн. Дархлаажуулалтын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн хүрээнд Монгол улсын засгийн газрын 2023 оны А/472 дугаар тогтоолоор “Заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлол”-ыг шинэчлэн баталсантай холбоотой орон нутгийн удирдлага, шийдвэр гаргагч нар болон эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн ажилчдад нийт 3 удаа давхардсан тоогоор 264 хүнд сургалт зохион байгуулсан. | |
| | | | | Хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо | 245 | 600 | 264 | | |
| 9 | МУ-ын Эрүүл мэндийн сайд Сүхбаатар аймгийн засаг засаг даргатай байгуулсан 3.10.1 | **Арга хэмжээ 1.4.1.9:** Эрүүл шүд арга хэмжээ 2024-2027 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах /МУ-ын ЗГ-ын 2023 оны А/322/ | | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 0 | 60 | 70 | ЗГ-ын 322 дугаар тогтоолын дагуу ЭМС, БШУС-ын хамтарсан А/27, А/25 дугаар тушаалын дагуу БШУГ-тай хамтран эрүүл шүд арга хэмжээний 5 зорилт 25 заалттай төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Эрүүл мэнд, боловсролын салбарт ажлын байранд шүдээ угааж хэвшицгээе цахим челлэнж зарлаж 12 ЭМБ, 15 ЕБС, СӨБ - ын байгууллагууд хамрагдсан. Албан байгууллагуудаа урин идэвхжүүлж байна.<br>ЭМГ-ын цахим хуудсанд 8 төрлийн мэдээ мэдээллийг байршуулан иргэдэд түгээсэн. хандалт - 5400<br>Амны хөндийн эрүүл ахуй сэдвээр 5 удаа танхимын сургалт зохион байгуулж 200 хүүхэд хамрагдсан байна. | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | МУ-ын Эрүүл мэндийн сайд Сүхбаатар аймгийн засаг засаг даргатай байгуулсан 3.10.3 | **Арга хэмжээ 1.4.1.10:** Эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд 2021-2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах/ЭМС-ийн А/760/ | | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 80 | 83 | 80 | Аймгийн засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/216 тоот захирамжаар эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус зөвлөлийг засаг даргын орлогчоор ахлуулан байгуулсан. 2024 онд “Эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний хүрээнд 6 зорилт, 28 арга хэмжээг төлөвлөсөн.<br>**Хийгдсэн томоохон ажлууд**:<br>-Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газартай хамтран “Ажлын байранд эх хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх” аяны хүрээнд 9 байгууллага 14,5 сая төгрөгийн санхүүжилт зарцуулж Эх хүүхдийн өрөөг бий болгосон байна<br>Эх хүүхдэд ээлтэй байгууллага, орон нутаг болох хөдөлгөөнийг 05 сарын 01-д эхлүүлсэн.<br>-Жирэмсэн үеийн эрсдэл хүндрэлээс сэргийлэх, Үжил халдвараас сэргийлэх, эх барихын шалтгаант цус алдалт, Хүнд,хүндэвтэр эх болон нярайд үзүүлэх тусламж үйлчилгээ, Хүүхдийн эрүүл мэнд хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх, үзлэг хийх арга зүй зэрэг 4 сэдвийн хүрээнд 7 удаагийн цахим болон танхимын сургалтыг өрх сумын эрүүл мэндийн төвийн 108 эмч, мэргэжилтнийг хамруулан зохион байгуулсан.<br>-АНЭ-ийн төрөх, хүүхдийн тасагт анхан шатны эрүүл мэндийн төвийн 31 эмчийг чадавхжуулах ажлын байрны тойрон сургалтыг зохион байгуулж эхэлсэн.<br>-Нярайн нүдний хавдрыг илрүүлэх улаан рефлексийн аргаар 264 нярайд үзлэг хийхэд өөрчлөлт илрээгүй.<br>Дутуу нярайн ретинопати илрүүлэгт 2 нярайг хамруулснаас өөрчлөлт илрээгүй.Түнхний эхо оношилгоог 264 нярайд хийсэн. Үүнээс: Type A-256 эрүүл, Type B-8 түнхний дутуу хөгжилтэй эмчилгээ зөвлөв. Type C-1 нярай түнхний | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | төрөлхийн мултралтай, дөрөөвч эмчилгээ хийж давтан үзлэг товлон зөвлөгөө өгсөн. Давтан үзлэгт 106 нярай хамрагдсан.<br><br>-Эрүүл мэндийн газрын даргаар батлуулсан удирдамжийн дагуу 2024 оны 05 сард “Стрептококкийн ангина, фарингит, хэрэх өвчин, хэрэхийн шалтгаант зүрхний олдмол гажгийг эрт оношлох чадавх олгох” сургалтыг ӨЭМТ, 12 сумын эрүүл мэндийн төв, АНЭ, Эрүүл мэндийн газар, ЕБС-ийн нийт 30 их эмч нарт зохион байгуулсан.<br><br>-НЭМҮТөвтэй хамтран “Нялхас, бага насны хүүхдийн хооллолтыг гамшгийн үеийн арга хэмжээтэй уялдуулах нь” сургалтыг Зудтай орон нутгийн 16 эрүүл мэндийн байгууллагын 32 хүүхдийн эмч, багийн бага эмч, мэргэжилтнийг хамруулан зохион байгуулсан.-4 их эмч,16 их эмч, хүүхдийн 5 их эмч мэргэжилтэн -1 | |
| 11 | МУ-ын Эрүүл мэндийн сайд Сүхбаатар аймгийн засаг засаг даргатай байгуулсан 3.10.2 | **Арга хэмжээ 1.4.1.11:** МУ-ын засгийн газрын 2023 оны 321 дүгээр тогтоол Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ | | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 0 | 80 | 30 | “Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх” арга хэмжээг удирдан зохион байгуулах орон тооны бус зөвлөлийг Аймгийн засаг даргын 2024 оны А/351 дүгээр захирамжаар байгуулсан. Орон тооны бус зөвлөл нь 1 удаа хуралдаж, 5 зорилт, 45 арга хэмжээ бүхий төлөвлөгөө батлуулсан.<br>Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд 16 эрүүл мэндийн байгууллагын цахим хуудсанд нийт 165 төрлийн мэдээллийг давхардсан тоогоор байршуулж дунджаар нэг мэдээлэлд 17800 хандалт авсан.<br>Орон нутгийн телевизтэй хамтран Эрүүл мэндийн газраас Халдварт өвчин, Халдварт бус өвчин, Угаарын хийн хордлого гэж юу вэ, Эрчүүдийн эрүүл мэнд, Өсвөр үеийн эрүүл | 50 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тээвэрлэх, боловсруулах устгах менежментийг сайжруулах тодорхой | | ХТОНӨҮГ-тай энгийн хог хаягдлыг тушаах | 0 | 30% | | байна. ЭМС-ын 2023 оны “Тоног төхөөрөмж орлогод авч хуваарилах тухай” A/248 дугаар тушаал, Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 7 дугаар сарын “Автоклав дагалдах хэрэгсэл хуваарилах тухай” A/62 дугаар тушаалаар 12 сумын эрүүл мэндийн төв, 2 ӨЭМТ-н халдварын сэргийлэлтийн үйл ажиллагааг бэхжүүлэх зорилгоор хог хаягдлын автоклавыг хуваарилсан бөгөөд ашиглалттай холбоотой эрүүл мэндийн төвүүдэд эрүүл мэндийн газрын даргын албан тоотыг хүргүүлэн, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн.<br>Хот тохижилт ОНӨААТҮГ-тай хамтран эрүүл мэндийн байгууллагууд жилд нэг удаа хамтран ажиллах гэрээ байгуулан энгийн хог хаягдлыг өдөр бүр хүлээлгэн өгч ажиллаж байна.<br><br>Аймгийн хэмжээнд хог хаягдлын автоклав ашиглалт 65 хувьтай байна. | |
| | | | | Хог хаягдлын автоклавын ашиглалт | 0 | 90% | | | |
| **Стратегийн зорилго 2.4: Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээ, алсын зайн технологийг өргөжүүлнэ** | | | | | | | | | |
| **Зорилт-2.4.1: Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдүүлж, алсын зайн технологийг сумын эрүүл мэндийн төвд нэвтрүүлэх** | | | | | | | | | |
| **Гүйцэтгэлийн зорилт-2.4.1** | | Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн эрүүл мэндийн мэдээллийн сан | | Шинээр цахим үйлчилгээг нэвтрүүлсэн байгууллагын тоо | 12 | 19 | 19 | Эрүүл мэндийн цахим үйлчилгээг 19 байгууллага e-mongolia 4.0, эмнэлгийн 7 үйлчилгээ, эрүүл мэндийн чиглэлийн халамжийн 5 үйлчилгээг цахимаар авах боломж бүрдсэн. | **70** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бүрдүүлж, алсын зайн технологийн чадавхыг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулах | | Алсын зайн оношилгоог шинээр нэвтрүүлсэн байгууллагын тоо | 12 | 16 | | 16 эрүүл мэндийн байгууллага Hinfo системийн шинэчлэлт хийгдсэнтэй холбоотой сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийн компьютерын үйлдлийн системд тохируулан шинээр татаж суулгасан. | |
| 1 | Монгол улсын ЭМСайд, АЗДаргатай 2024 онд хамтран ажиллах гэрээний 3.12.1 | **Арга хэмжээ-2.4.1.1:** Эрүүл мэндийн байгууллагыг өндөр хурдны интернэт сүлжээнд холбоно. | УТ, ОНТ | Өндөр хурдны интернэт сүлжээнд холбогдсон ЭМБ-н тоо | 3 | 3 | 2 | Өндөр хурдны интернэт сүлжээнд холбогдсон эрүүл мэндийн байгууллагын тоо 2-р нэмэгдсэн. | 100 |
| 2 | Монгол улсын ЭМСайд, АЗДаргатай 2024 онд хамтран ажиллах гэрээний 3.12.2 | **Арга хэмжээ-2.4.1.2:** Анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын телемедцин ашиглалтыг сайжруулах, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлнэ. | УТ, ОНТ | Эрүүл мэндийн байгууллагын тоо | 12 | 19 | 19 | Эрүүл мэндийн яам,эрүүл мэндийн хөгжлийн төв, бусад эрүүл мэндийн байгууллагуудтай 2-р улиралд АНЭ яаралтай тусламжийн төвөөр телемедцин ашиглан сум өрхтэй 4 удаагийн сургалт зохион байгуулагдсан. | 100 |
| 3 | Монгол улсын ЭМСайд, АЗДаргатай 2024 онд хамтран ажиллах гэрээний 3.12.3 | **Арга хэмжээ-2.4.1.3:** Эрүүл мэндийн мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн системийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай сервер, тоног | УТ, ОНТ | Эрүүл мэндийн байгууллагын хувь | 50% | 80% | 50 | Эрүүл мэндийн газар Өрх сумын эрүүл эндийн төвүүдийн мэргэжилтэн албан хаагчдын компьютерт нэг ижил үйлдлийн систем суулгаж, вирусийн эсрэг программ суулгасан. | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | төхөөрөмжөөр хանган байнгын хяналт тавьж ажиллана. | | | | | | | |
| 4 | Монгол улсын ЭМСайд, АЗДаргатай 2024 онд хамтран ажиллах гэрээний 3.12.4 | **Арга хэмжээ-2.4.1.4:** Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг өөрийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудад хийж дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана. | УТ, ОНТ | Эрсдэлийн үнэлгээ хийсэн эрүүл мэндийн байгууллагын тоо | 0 | 15 | 15 | Firewall төхөөрөмж суурилуулсан. Тайланг тагнуулын газарт мэдээлсэн. | 70 |
| | | | | Зөвлөмж хүргүүлсэн ЭМБ тоо | 0 | 15 | | | |
| | | | | Хэрэгжилтийн хувь | 0 | 70% | | | |
| 5 | АЗДаргатай 2024 онд хамтран ажиллах гэрээнд | **Арга хэмжээ-2.4.1.5:** ЭМС-ын 2022 оны А/346 дугаар тушаалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлэх, хэрэгжилтийг хангуулах | УТ, ОНТ | Эрүүл мэндийн байгууллагын тоо | 16 | 19 | 16 | Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан хойшилсон 2023 оны жилийн эцсийн хяналт үнэлгээг 12 сум 2 өрхийн эрүүл мэндийн төв нийт 14 байгууллагад зохион байгуулж зөвлөмж, зөвлөгөө өгсөн. Төлөвлөгөөт бус хяналт үнэлгээг АНЭ-д зохион байгуулсан.<br>2024 оны хагас жилийн дэмжлэгт хяналтыг 2 өрхийн эрүүл мэндийн төв, 2 сумын эрүүл мэндийн төвд хийж арга зүйн зөвлөгөө өгсөн. | 100 |
| | | | | Зөвлөмж хүргүүлсэн ЭМБ тоо | 15 | 15 | 16 | | |
| | | | | Хэрэгжилтийн хувь | 0 | 80 | 70 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | АЗДаргатай 2024 онд хамтран ажиллах гэрээнд | **Арга хэмжээ-2.4.1.6:** Харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээний бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад мэдээ цуглуулах анхан шатны бүртгэлийн маягтын хөтлөлтийн байдал, бүртгэл мэдээллийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах, мэргэжлийн арга зүй, зөвлөмжөөр байнга хангах | УТ, ОНТ | Эрүүл мэндийн байгууллагын тоо | 10 | 19 | 19 | 2024 оны 1-6 сарын эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг анхан шатны бүртгэлийн маягтын хөтлөлтийн дагуу 19 байгууллагын бүртгэл мэдээллийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна. | 100 |
| **Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт**, **арга хэмжээ** | | | | | | | | | |
| 1 | МУ-ын Эрүүл мэндийн сайд Сүхбаатар аймгийн засаг засаг даргатай байгуулсан гэрээ 3.11.4 | **Арга хэмжээ-3.1.1.1:** Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй гүйцэтгэлийн гэрээ байгуулж, үйл ажиллагааны гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж ажиллана | УТ | Гүйцэтгэлийн хяналт хийсэн тоо<br><br>Хэрэгжилтийн хувь | 2<br><br>70 | 2<br><br>75 | 2<br><br>70 | Өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн гүйцэтгэлд үнэлгээ хийж цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж хүргүүлэн ажилласан. Энэрэлт- Ачтан, Энхлэн-Ачтан ӨЭМТ-тэй гурвалсан гэрээ байгуулсан. Энэрэлт-Ачтан - 80 хувь, Энхлэн -Ачтан -70 хувьтай үнэлэгдсэн.<br>Хагас жилийн гэрээний хэрэгжилтийг 7 сарын 05-ны дотор дүгнэнэ. | 100 |
| 2 | МУ-ын Эрүүл мэндийн сайд Сүхбаатар аймгийн засаг засаг даргатай | **Арга хэмжээ-3.1.1.2:** Сум, өрхийн эрүүл мэндийн төвөөс үзүүлэх гэрийн эргэлт, | УТ | Гэрийн эргэлт, идэвхтэй хяналтын хувь | 4.4 | 10 | 3.4%<br>12.3% | Анхан шатны эрүүл мэндийн төвүүдийн гэрийн эргэлтийн хувь 3.4 хувь, идэвхтэй хяналтын үзлэг 12.3 хувь байна | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулсан гэрээ 3.11.4 | идэвхтэй хяналтын үзлэгийг нэмэгдүүлэх | | | | | | | |
| **4.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ** | | | | | | | | | |
| **Стратегийн зорилго 4.1: Эрүүл мэндийн салбарт ажиллаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдын чадавхыг сайжруулах, хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, иргэд рүү чиглэсэн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах.** | | | | | | | | | |
| **Зорилт-4.1.1: Эмч, эмнэлгийн мэргэжилтэн нарыг чадавхыг сайжруулах, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгож амьдралын зөв дадал хэвшлийг бий болгох** | | | | | | | | | |
| 1 | Сүхбаатар аймгийн 2020-2028 оны хөгжлийн хэтийн зорилтын 2.4.1 АЗД-ын 2020-2024 оны ҮАХ-ын 2.1.6<br><br>Эрүүл мэндийн сайдын “Эрүүл мэндийн ажилтны 2024-2025 оны төгсөлтийн дараах сургалтын чиглэл, элсэлтийн хяналтын тоо, сургалтын зардал батлах тухай” | **Арга хэмжээ-4.1.1.1:** Эмч эмнэлгийн мэргэжилтнийг гадаад сургалтад хамруулах | ОНТ | Сургалтад хамрагдсан эмч эмнэлгийн мэргэжилтний тоо | 2 | 2 | 8 | -Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/422 дугаар тушаалын дагуу БНСУ-д удирдах ажилтныг чадавхжуулах сургалтад Эрүүл мэндийн газрын хэлтсийн дарга 1, АНЭ-н дарга 1, нийт 2 удирдах ажилтан<br>-БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод Уламжлалт анагаах ухааны 14 хоногийн сургалтад 1 их эмч<br>-Эрүүл мэндийн сайдын 2024 оны “Гадаад сургалтад суралцуулах тухай” А/199 дүгээр тушаалын дагуу сумын эрүүл мэндийн төвөөс 2 бага эмч, 3 сувилагчийг тус тус сургалтад хамруулсан.<br>-Сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн ажилтны тоо-8 | 100 |
| 2 | | **Арга хэмжээ-4.1.1.2:** Эмч эмнэлгийн мэргэжилтний ажлын байрны урт богино хугацааны | | Сургалтад хамрагдсан эмч эмнэлгийн мэргэжилтний тоо | 3 | Гүйцэтгэлээр | 17 | 12 сум, 2 өрхийн эмнэлгээс хүүхэд, эх барих хариуцсан 1 эмчийг АНЭ-н Хүүхэд болон Төрөх тасагт ажлын байрны 5 хоногийн чадавхжуулах сургалтад хамруулахаар төлөвлөгөө, сургалтын хуваарь гарсан. Энэ хуваарийн дагуу хүүхдийн тасагт 5 их эмч, төрөх тасагт 3 их эмч | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | | сургалтыг тогтмол зохион байгуулах | | | | | | тойрон сургалтаа хийгээд байна. Бусад хүмүүс хуваарийн дагуу хамрагдана.<br>2024 оны 2-р улиралд ХӨЦМ, хүүхдийн эрэмбэлэн ангилалтын чиглэлээр сургалт явуулахаар төлөвлөгөө гарсан.<br>2024 оны 06 сард ажлын байрны дадлагажих сургалтын удирдамжийн дагуу УАУНЭ-т сум, өрхийн сэргээн засах эмчилгээний 13/9 сувилагчийг ажлын байрны дадлагажих сургалтад хамруулсан. | |
| 3 | | **Арга хэмжээ-4.1.1.3:**<br>Эмч эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр ажил мэргэжлийн уралдаан, өдөрлөг, аян, хэлэлцүүлэг зохион байгуулах | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 1 | 2 | 2 | Мэргэшлийн зэргийн шалгалтад 11 сувилагч тусгай мэргэжилтэн хамрагдаж зэрэгтэй сувилагч нарын тоо нэмэгдсэн.Үүнд:<br>- Зөвлөх зэрэг - 1<br>- Тэргүүлэх зэрэг - 2<br>- Ахлах зэрэг - 8<br>ЭМЯ-аас зохион байгуулсан“ Сувилагч танаараа бахархъя” арга хэмжээнд 45 сувилагч тусгай мэргэжилтэн хамрагдаж “ Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал” 4 чиглэлээр хэлэлцүүлэгт оролцсон. | 100 |
| 4 | МУ-ын ЗГ-ын 2020 оны 96-р тогтоол “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III” | **Арга хэмжээ-4.1.1.4:**<br>Эрүүл мэндийн салбарын албан хаагчдыг Монгол бичгийн анхан шатны цахим сургалтад хамруулах | 0.3 | Хамрагдсан хүний тоо | 10 | 60 | 20 | Монгол бичгийн анхан шатны цахим сургалтад 20 албан хаагч хамрагдаж байна. | 50 |
| 5 | МУ-ын Эрүүл мэндийн сайд Сүхбаатар аймгийн засаг | **Арга хэмжээ-4.1.1.5:**<br>Иргэд рүү чиглэсэн нийгмийн эрүүл | | Зохион байгуулсан сургалтын тоо | 60 | 65 | 35 | Эрүүл мэндийн газраас нийт 35 төрлийн сургалт зохион байгуулагдсан. Үүнээс танхим- | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | засаг даргатай байгуулсан гэрээ | мэндийн сургалт, сурталчилгааны ажлыг бүх сувгийг ашиглан зохион байгуулах | | Хамрагдсан Иргэдийн хувь | 60 | 70 | | 21, цахим - 14 сургалтыг давхардсан тоогоор 1545 эмч эмнэлгийн ажилчид болон иргэдэд зохион байгуулсан.<br><br>Өрх, Сумын эрүүл мэндийн төвүүд Үүрэн телефоны Юнител ХХК-тай хамтран Осголт хөлдөлт, Томуу томуу төст өвчин зэрэг сэдвүүдээр 10748 иргэнд масс мессежийг хүргэн ажилласан.<br><br>Орон нутгийн телевизтэй хамтран Эрүүл мэндийн газраас Халдварт өвчин, Халдварт бус өвчин, Угаарын хийн хордлого гэж юу вэ, Эрчүүдийн эрүүл мэнд, Өсвөр үеийн эрүүл мэнд, Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, Цагаан сарын баярыг тохиолдуулан хүүхдийг ахуйн ослоос сэргийлэх зөвлөмж, баярын өдрүүдээр иргэд эрүүл мэндийн тусламж хэрхэн авах, Хүнсний бүтээгдэхүүн худалдаж авахдаа анхаарах зүйл, Жирэмсэн үеийн аюултай шинж тэмдэг зэрэг нийт 49 мэдээ мэдээллийг 392 удаагийн давтамжтайгаар байршуулан давхардсан тоогоор 150000 иргэний хандалтыг авсан. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | МУ-ын Эрүүл мэндийн сайд Сүхбаатар аймгийн засаг засаг даргатай байгуулсан гэрээ 3.10.2 | **Арга хэмжээ 4.1.1.6** “Аймгийн хэмжээнд Бүх нийтийн гүйлт, витаминжуулах” аян | | Бүх нийтийн гүйлтэд тогтмол хамрагдсан байгууллагын тоо | 60 | 65 | 53 | Энэ жилдээ-Эрүүл жиндээ 2 аяны хүрээнд Бүх нийтийн кросс гүйлтийг 12 сумын ЭМТөвүүд орон нутгийн ЗДТГ болон албан байгууллага, ААНэгжүүдтэй хамтран 2024 оны 4 дүгээр сар 13-ны өдрөөс эхэлж найман 7 хоног 53 байгууллага хамтран зохион байгуулж оролцогчдыг аминдэмийн бэлдмэл, сүү цагаан идээгээр урамшуулан ажиллаж давхардсан 7000 гаруй аж ахуйн нэгж, албан байгууллагын ажилтан албан хаагчид, иргэд хамрагдаад байна. Энэ үйл ажиллагаа 10 сарын 02-нь хүртэл үргэлжилнэ. | 90 |
| | | | | Оролцсон хүний тоо | 8000 | 10000 | 7000 | | |
| 7 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлиг | **Арга хэмжээ-4.1.1.7:** Аймгийн хэмжээнд бие бялдрын чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилыг 19-64 насны иргэдийг хамруулж, программд шивэх | | Байгууллагын тоо Хамрагдсан иргэдийн хувь | 11% | 15% | - | Хугацаа болоогүй. 3 дугаар улиралд иргэдийг чийрэгжүүлэлтийг түвшин тогтоох сорилд идэвхжүүлэн хамруулж программд шивнэ. | - |
| | | | | Шивэлтийн хувь | 99% | 86.6% | | | |
| 8 | МУ-ын Эрүүл мэндийн сайд Сүхбаатар аймгийн засаг засаг даргатай байгуулсан гэрээ 3.10.8 | **Арга хэмжээ-4.1.1.8:** Хүүхэд өсвөр үеийнхэнд сэтгэлзүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах салбар дундын хамтын ажиллагаар хангаж ажиллана. | | Өсвөр үеийн кабинетаар үйлчлүүлсэн өсвөр үеийн хүүхдийн тоо | 1748 | 2000 | 802 | Эхний хагас жилийн байдлаар өсвөр үеийн кабинетаар 802 хүүхэд үйлчлүүлж тусламж үйлчилгээ авсан байна. Өсвөр үеийн эрүүл мэндийн боловсрол олгохоор Амны хөндийн эрүүл мэнд, Эрүүл хооллолт, Ус ба эрүүл мэнд, Сүрьеэ өвчин, Тамхи түүний хор нөлөө, Өсвөр насны хүүхдүүдийн сэтгэцийн эрүүл мэнд зэрэг сэдвүүдээр нийт 5 удаа сургалт зохион байгуулж 200 хүүхэд хамрагдсан. | 100 |
| | | | | Зохион байгуулсан сургалтын тоо | 9 | 12 | 5 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хамрагдсан хүүхдийн тоо | 6752 | 7000 | | | |
| 9 | МУ-ын Эрүүл мэндийн сайд Сүхбаатар аймгийн засаг засаг даргатай байгуулсан гэрээ 3.2 | **Арга хэмжээ-4.1.1.9:** Оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аяны хүрээнд оюутан залуучуудыг эрт илрүүлэх, үзлэг, шинжилгээ, оношилгоонд бүрэн хамруулах | 0.5 | Үзлэг шинжилгээнд хамрагдсан оюутнуудын хувь | 90 | 90 | - | Хугацаа болоогүй | |
| | | | | Сургалтад хамрагдсан оюутнуудын хувь | 80 | 85 | | | |
| 10 | ЭМС-ын 2017 оны А/472 | **Арга хэмжээ-4.1.1.10:** Эрүүл ажлыг байрыг дэмжих үйл ажиллагаар зохион байгуулах | 0.5 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 3 | 5 | 1 | 2024 оны эхний хагас жилийн байдлаар ЭМС-ын 2017 оны А/472 дугаар тушаалын дагуу нийт 7 байгууллага төлөвлөгөө ирүүлсэн байна. | 50 |
| | | | | Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоо | 11 | 15 | 7 | | |
| 11 | МУ-ын Эрүүл мэндийн сайд Сүхбаатар аймгийн засаг засаг даргатай байгуулсан гэрээ 3.10.1, 3.10.8 | **Арга хэмжээ-4.1.1.11:** Сургуулийн өмнөх болон сургуулийн хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах дэмжих, амны хөндийн эрүүл мэнд, осол гэмтлээс сэргийлэх, | 1.5 | Хамтран ажилласан байгууллагуудын тоо | 3 | 4 | 7 | Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах дэмжих, амны хөндийн эрүүл мэнд, осол гэмтлээс сэргийлэх чиглэлээр нийт 7 албан байгууллагатай хамтран үйл ажиллагаа зохион байгуулсан.<br>Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх аяныг **“Хүүхдийн аюулгүй байдал -Таны хариуцлагаас”** уриан дор 5 байгууллага хамтран тэмдэглэн өнгөрүүлсэн.<br>-Жил бүрийн 3 дугаар сарын 22-ны өдрийг “Дэлхийн усны өдөр” болгон тэмдэглэн өнгөрүүлдэг бөгөөд энэ жил “УС БА | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | ЭНХТАЙВАН” уриан дор Сүхбаатар аймгийн хэмжээнд усан хангамж болон ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах арга зам, тэдгээрийн хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг сурталчлан тариулах зорилгоор “Дэлхийн усны өдөр”-ийг тохиолдуулан “Ус ба эрүүл мэнд” сэдвээр 4 чиглэлээр өсвөр үеийн хүүхдүүдэд сургалт зохион байгуулж ЕБС-ийн 30 сурагч хамрагдсан.Улаан загалмайн хорооны гишүүдэд “Дэлгэцийн донтолт” “Эрүүл зөв хооллолт” “Тамхины хэрэглээ түүний хор хөнөөл” “Амны хөндийн эрүүл мэнд” сэдвүүдээр сургалт зохион байгуулж 40 гишүүд хамрагдсан. | |
| | | | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2 | 5 | 2 | Эрүүл мэндийн газар, Орон нутгийн телевиз, Өрх сумын эрүүл мэндийн төвүүдийн цахим хуудсаар дамжуулан Эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийн осол гэмтлийн эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх 22 төрлийн постер, 22 төрлийн зөвлөмж 4 видеог 150 удаагийн давтамжтайгаар хүргэсэн. Хандалт – 4520, хуваалцах- 75, үзэлт – 2560 байна.<br><br>Осол гэмтлээс сэргийлэх аяны хүрээнд Аймгийн нэгдсэн эмнэлэг өдөрлөг зохион байгуулсан. Осол гэмтлээс сэргийлэх, гэмтсэн тохиолдолд авах арга хэмжээний талаар зөвлөгөө мэдээлэл өгч Гэмтэл мэс заслын тасгийн үйл ажиллагааг сурталчилсан. Нийт 30 хүний амин үзүүлэлт үзэж, 8 төрлийн 120 ширхэг гарын авлагыг тараасан. Мөн хэвтэн эмчлүүлж буй иргэдэд осол гэмтлээс сэргийлэх сургалтыг 10 тасгийн сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн өдөр тутмын сурталтандаа нэмэлтээр оруулж Халуун хоол цайнд түлэгдэхээс сэргийлье, Авто ослоос сэргийлье, | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Явганаас унаж бэртэхээс сэргийлье, Нохойд хазуулахаас сэргийлье, Гэр бүл, аюулгүй орчин, Түлэгдэл , зам тээврийн ослоос сэргийлье, ахуйн осол гэмтлээс сэргийлье, осголт, хөлдөлт, нярайн осол гэмтлээс сэргийлье зэрэг сэдвээр 97 удаа давхардсан тоогоор 2595 хүнд танхимын сургалт хийсэн. | |
| 12 | Монгол улсын хууль 2019 он ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай | **Арга хэмжээ-4.1.1.12:** Сургуулийн өмнөх боловсролын хоол үйлдвэрлэл ЕБС-ын үдийн хоол хөтөлбөрийн хэрэгжүүлэх сургалтыг зохион байгуулах | 0.6 | Зохион байгуулсан сургалтын тоо | 1 | 2 | 1 | НЭМҮТ-ийн Хоол судлалын албанаас зохион байгуулагддаг Сургуулийн өмнөх боловсролын хоол үйлдвэрлэл ЕБСургуулийн үдийн хоолны хөтөлбөрийн тогооч нарын хүүхдийн хоолны талаарх мэдлэгийг дээшлүүлэх, мэргэжил, арга зүйгээр хангах 5 өдрийн сургалтад 19 тогооч хамрагдсан. 4-р улиралд тогооч нарын нэгдсэн сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж байна | 100 |
| | | | | Хамрагдсан тогоочийн тоо | 42 | 60 | 19 | | |
| 13 | МУ-ын Эрүүл мэндийн сайд Сүхбаатар аймгийн засаг засаг даргатай байгуулсан гэрээ 3.2 | **Арга хэмжээ-4.1.1.13:** Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих, эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах, эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулах | 2.5 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 5 | 6 | 4 | Нийт 4 арга хэмжээ зохион байгуулсан.<br>-Эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлэх зорилгоор Цэргийн төв эмнэлгийн нарын мэргэжлийн эмч нар 9 суманд үзлэг, оношилгоо, шинжилгээг зохион байгуулан ажилласан.Үзлэгт нийт 2151 иргэн хамрагдсан.<br>-Малчин эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх зорилгоор Лагийн нуурын отрын штаб байгуулан Сүхбаатар, Эрдэнэцагаан, Баруун-Урт сумын нийт 121 иргэнд эрүүл мэндийн тусламжийг үзүүлсэн.<br>-АНЭ-ийн мэс засал-Урологийн кабинет нь 7 хоногийн мягмар, пүрэв гарагуудад ажиллаж байна. Урологийн эмч давхардсан тоогоор нийт 207 иргэнд үзлэг, оношилгоо хийсэн .<br>-Эрэгтэйчүүд олноор ажиллаж, суралцдаг салбар буюу ЗХ-ний 338 дугаар цэргийн анги, 168 дугаар анги, Цагдаагийн газар, Онцгой | 90 |
| | | | | Урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдсан эрэгтэйчүүдийн тоо | 3560 | 5300 | | | |
| | | | | Сургалт сурталчилгаанд хамрагдсан | 8560 | 12500 | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | эрэгтэйчүүдийн тоо | | | 5620 | байдлын газар, ШШГГ, Эрчим, Прокурорын газар, МСҮТ-ийн дотуур байр зэрэг 10 байгууллагын 597 ажилтан, албан хаагч, цэрэг, сонсогчдод нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр танхимын сургалтыг зохион байгуулсан. | |
| 14 | МУ-ын Эрүүл мэндийн сайд Сүхбаатар аймгийн засаг засаг даргатай байгуулсан гэрээ 2.3 | **Арга хэмжээ-4.1.1.14:** Эрүүл мэндийн боловсрол олгох МСС-ны тэмдэглэлт өдрүүдийг зохион байгуулах | 10.0 | Зохион байгуулсан тэмдэглэлт өдрүүдийн тоо | 26 | 30 | 9 | Засгийн газрын 224 дүгээр тогтоолын дагуу хагас жилийн байдлаар байдлаар 9 тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд үйл ажиллагаа зохион байгуулан ажилласан. Мөн ЭМЯ, НЭМҮТ, Гэмтэл согог судлалын үндэсний төвүүдийн цахим хуудсанд байршуулсан зөвлөмж, постер, мэдээ мэдээллийг тогтмол эрүүл мэндийн газрын цахим хуудас болон 2 өрх, 12 сумын эрүүл мэндийн төвүүдээр дамжуулан ард иргэдэд хүргэсэн. Үүнд:<br>❖ Осол гэмтлээс урьдчилан сэргийлье<br>❖ Хорт хавдрын эрсдэлт хүчин зүйл<br>❖ Архи, тамхины хор уршиг<br>❖ Сүрьеэ өвчин гэж юу вэ<br>❖ өсвөр үеийн эрүүл мэнд<br>❖ давсны хэрэглээг бууруулах 7 хоног<br>❖ дэлхийн усны өдөр<br>❖ архидан согтуурахаас сэргийлье 7 хоног<br>зэрэг сэдвүүдийн хүрээнд видео мэдээ, мэдээллийг хүргэж ажилласан. | 90 |
| | | | | МСС-нд хамрагдсан хүн амын эзлэх хувь | 25 | 40 | 20 | | |
| 15 | ЭМС-ын 2019 оны А/290 | **Арга хэмжээ-4.1.1.15:** 6 сар хүртэл эхийн сүүгээр дагнан хооллолтын хувийг нэмэгдүүлэх, эхийн сүүгээр хооллолт 10 алхмыг хэрэгжүүлэх | | Эхийн сүүгээр хооллолтын хувийг нэмэгдүүлэх | 53% | 60% | 55.9% | Сар бүр эхийн сүүгээр хооллолтын мэдээг сум, өрхийн ЭМТ-өөс авч нэгтгэсэн үүний үр дүнд эхийн сүүгээр дагнан хооллолт 88.1%, 06-23 сартай хүүхдийн эхийн сүүгээр хооллолт 55.9%-тай байна. Эхийн сүүгээр хооллолтын ач холбогдол, ажлын байранд эхийн сүүгээр хооллолтын булан ажиллуулах уриалга гарган Уртын гэгээ ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан 2 төрлийн мэдээллийг 4 самбарт байршуулсан. | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | ЭМТөвөөс эхний 5 сарын байдлаар 0-5 насны 526 хүүхэд, давхардсан тоогоор жирэмсэн 462, хөхүүл 197 эхэд хооллолтын зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. | |
| 16 | ЭМС-ын 2021 оны А/379 | **Арга хэмжээ-4.1.1.16:**<br>Нялх, бага насны хүүхдийн хоол тэжээлийн зөвлөгөө өгөх, хоол тэжээлийн цочмог дутлыг илрүүлэх орон нутгийн сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулах<br>Хоол тэжээлийн дутагдалтай хүүхдийн судалгааг сар бүр авч хэвших, эмчлэн эрүүлжүүлэх. | Улс, Орон нутгийн төсөв | Сургагч багш бэлтгэгдсэн байна | 74 | 100 | 106<br>6 | НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр “Нялхас, бага насны хүүхдийн хооллолтыг гамшгийн үеийн арга хэмжээтэй уялдуулах нь” сургалтыг 16 эрүүл мэндийн байгууллагын 32 хүүхдийн эмч, багийн бага эмч, мэргэжилтнийг хамруулан НЭМҮТөвтэй хамтран зохион байгуулсан. Нийт давхардсан тоогоор 106 сургагч багшийг бэлтгээд байна.<br><br>Сар бүр эхийн сүүгээр хооллолтын мэдээг сум, өрхийн ЭМТ-өөс авч нэгтгэсэн үүний үр дүнд эхийн сүүгээр дагнан хооллолт 88.1%, 06-23 сартай хүүхдийн эхийн сүүгээр хооллолт 55.9%-тай байна.<br><br>Сар бүрийн мэдээний үр дүнд УИДуталтай 54 илрүүлсэн мөн Хоол тэжээлийн цочмог дуталтай 15 хүүхдэд ЭБХоолыг заабрын дагуу өгөн хяналтдаа авч ажиллаж байна. | 100 |
| | | | | Мэдээг сар бүр авч хэвших | 0 | 10 | | | |
| | | | | Эрүүлжсэн хүүхдийн тоо | 0 | 54 | | | |
| 17 | МУ-ын Эрүүл мэндийн сайд Сүхбаатар аймгийн засаг засаг даргатай байгуулсан гэрээ 2.3 | **Арга хэмжээ-4.1.1.17:**<br>Эрдэм шинжилгээ судалгааны ажил зохион байгуулах, нотолгоонд суурилсан анагаах ухааныг хөгжүүлэх | 1.0 | Эрүүл мэндийн байгууллагын дунд онол практикийн тэмцээн зохион байгуулах, илтгэлийн тоо | 9 | 12 | 11 | Сүхбаатар аймгийн Анхны сувилагч, эм зүйч, эмийн сангийн эрхлэгчийн нэрэмжит онол практикийн бага хурал 2024 оны 05 дугаар сарын 10-ний өдөр Эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй асуудлыг судлах, эмнэлгийн мэргэжилтний судалгааны ур чадварыг дээшлүүлэх, нотолгоонд суурилсан анагаах ухааныг хөгжүүлэх зорилгоор Аймгийн ИТХ, Нийгмийн бодлогын хэлтэс, Эхийн Элбэрэл - Дамба сан болон АШУҮИС хамтран зохион байгуулж 50 гаруй оролцогч 11 илтгэл | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хэлэлцүүлсэн. Гранпри хүртсэн илтгэлийн хураангуйг Сүхбаатарын өнгө сонины 05 дугаар сарын 27-ний өдрийн шинэ дугаарт, шилдэгт шалгарсан илтгэлүүд Зүүн бүсийн эрдэм шинжилгээний хуралд оролцож “Судлаач эмч-2024” дугаарт хэвлэгдсэн. | |
| 18 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай - 2008 он | **Арга хэмжээ-4.1.1.18:** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, ЭМБ-дад дэмжлэгт хяналт хийж, зөвлөн туслах, сургалт мэдээлэл хийх | | Дэмжлэгт хяналт хийгдсэн ЭМТ-ийн тоо | 8 | 12 | 6 | Аймгийн нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг, Энэрэл ачтан, Энхлэн ачтан Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, тогтоомж , дүрэм, журам аюулгүй ажиллагааны заавар журам стандартыг мөрдөхөд гарсан тушаал албан даалгаврын биелэлтийг үнэлэх, дэмжлэгт хяналт зөвлөн туслах хийх удирдамжийн дагуу ажиллаж зөвлөмжийг хүргүүлсэн.<br><br>Мөн АНЭ, УАУНЭ, ӨЭМТөвийн ХАБЭА-н ажилтан, хавсран гүйцэтгэдэг 35 эмч, эмнэлгийн ажилтнуудад хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг мөрдөх, тэдгээрт нийцүүлэн дотоод дүрэм, журмыг боловсруулан хэрэгжүүлж, аливаа аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах мэдлэг ур чадвар дээшлүүлэх зорилгоор сургалтыг зохион байгуулсан. | 90 |
| | | | | Танхимын сургалт зохион байгуулах | 5 | 6 | 2 | | |
| 19 | Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль 5,6,2 | **Арга хэмжээ-4.1.1.19:** **Энэ жилдээ эрүүл жиндээ-2** аяны хүрээнд Эрүүл мэндийн салбарын хэмжээнд Спортын наадам зохион байгуулах | 5.0 | Зохион байгуулсан байна | 1 | 1 | - | хугацаа болоогүй | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 20 | Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль 5.5.1 | **Арга хэмжээ-4.1.1.20:** Иргэд аж ахуй нэгж албан байгууллагуудад эрүүл зөв хооллолтын хэвшүүлэх зорилгоор сар бүрийн 3-7 хооронд эрүүл зөв хооллолтын танхимд зөвлөгөө мэдээлэл өгөх | | Танхимд зохион байгуулсан сургалтын тоо | 5 | 10 | 8 | Эрүүл зөв хооллолтыг хэвшүүлэх зорилгоор Зохистой хооллолт, эрүүл идэвхтэй амьдрал, хүнсний аюулгүй байдал сэдэвт ухуулаг нөлөөллийн ажил, сургалтыг 8 байгууллагын 300 гаран ажилтан, албан хаагчид иргэдэд зохион байгуулсан. | 100 |
| **Стратегийн зорилго .4.2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулан тусламж үйлчилгээний төрөл, гүйцэтгэлтэй уялдсан магадлан итгэмжлэл бүхий чанарын удирдлагыг нэвтрүүлэх** | | | | | | | | | |
| **Зорилт 4.2.1: Эрүүл мэндийн байгууллагуудын чанар аюулгүй байдлын албаны үйл ажиллагааг тогтмолжуулан гүйцэтгэлтэй уялдсан магадлан итгэмжлэл бүхий чанарын удирдлагыг нэвтрүүлнэ** | | | | | | | | | |
| Зорилт-4.2.1: | | Эрүүл мэндийн байгууллагуудын чанар аюулгүй байдлын албаны үйл ажиллагааг тогтмолжуулан гүйцэтгэлтэй уялдсан магадлан итгэмжлэл бүхий чанарын удирдлагыг нэвтрүүлнэ | Улсын төсөв | Магадлан итгэмжлэлд тэнцсэн ЭМБ-ын тоо | 10 | 6 | 6 | 2024 онд 6 эрүүл мэндийн байгууллага магадлан итгэмжлэлд хамрагдахаар төлөвлөсөн. 1-р улиралд магадлан итгэмжлэлийн үнэлгээнд УАУНЭ, Асгат, Түвшинширээ сумын эрүүл мэндийн төв хамрагдсан. 2-р улиралд Энхлэн-Ачтан, Энэрэлт-Ачтан өрхийн ЭМТ, Наран сумын ЭМТ тус тус хамрагдахаар төлөвлөгдөж магадлан итгэмжлэлийн цахим программд тус бүр 36 төрлийн 180 материалыг оруулаад байна . | **100** |
| 1 | МУ-ын Эрүүл мэндийн сайд Сүхбаатар аймгийн засаг | **Арга хэмжээ 4.2.1.1:** Магадлан итгэмжлэлийн шинжээчдийн | ЭМЯ | Магадлан итгэмжлэл орох эрүүл мэндийн | 10 | 6 | 6 | 2024 оны 2 дугаар улирлын байдлаар ЭМЯ, ЭМХТ-тэй хамтран УАУНЭ, Асгат, Түвшинширээ сумын эрүүл мэндийн төвүүдийг | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | засаг даргатай байгуулсан гэрээ 3.2.3, 3.2.5.5. | багтай хамтран ажиллаж, ЭМБ-уудыг үнэлгээнд хамруулна | | байгууллагын тоо | | | | магадлан итгэмжлэлийн ажлын байрны үнэлгээнд хамруулсан. | |
| 2 | Эрүүл мэндийн сайдын 2023 оны 412 дугаар тушаал | **Арга хэмжээ 4.2.1.2:** Магадлан итгэмжлэлд орох ЭМБ-уудыг явцын үнэлгээнд хамруулна | 2.0 | Магадлан итгэмжлэлийн явцын үнэлгээнд хамрагдсан ЭМБ-ын тоо | 10 | 10 | 100 | 2024 оны 2 дугаар улирлын байдлаар явцын үнэлгээнд 6 эрүүл мэндийн байгууллагыг хамруулсан . | 100 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 4.3: Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлнэ** | | | | | | | | | |
| **Зорилт 4.3.1: Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдал хангамж хүртээмжийг нэмэгдүүлэн зайлшгүй шаардлагатай эмийн хүртээмжийг нэмэгдүүлнэ** | | | | | | | | | |
| **Зорилт 4.3.1:** | | Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдал хангамж хүртээмжийг нэмэгдүүлэн зайлшгүй шаардлагатай эмийн хүртээмжийг нэмэгдүүлнэ | Улсын төсөв | Зайлшгүй шаардлагатай эмийн хангалтын хувь | 83 | 85 | 90 | Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдал хангамж хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд АНЭ, Өрх, сумын эрүүл мэндийн төвд хэрэглэж байгаа нэг удаагийн зүү тариур, уян зүү, дуслын системийн чанар, аюулгүй байдалд тандалт судалгаа болон жилийн дундаж хэрэглээг тооцон ажиллах судалгааг авч систем, 3 гр, 1, 10 гр , уян зүү 18, 20 G өргөн хэрэглэгддэг тооцоолол гарсан. Эрүүл мэндийн салбарын нийт 43/41 байгууллагаас Амин чухал, ЗШЭ-ийн судалгааг авахад ЗШЭ-ийн хангалт- **82%,** Амин чухал эмийн хангалт-94,2%**,** Дундаж хангалт- **88 %** байна. | **90** |
| 1 | Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги | **Арга хэмжээ 4.3.1.1:** “АИТХ-аас гарсан шийдвэрийн дагуу | - | Гэрээ байгуулсан байгууллагын тоо | 0 | 11 | 100 | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хурлаар Эмийн эргэлтийн сангийн статусын талаар хэлэлцэж | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөө 3.5. | эмийн сангуудтай хамтран ажиллах гэрээ байгуулах | | | | | | "хувийн хэвшил"-д шилжүүлж хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. | |
| 2 | Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө 3.5.2 | **Арга хэмжээ.4.3.1.2:** Эм зүйн тусламж үзүүлдэг байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавина | Улсын болон орон нутгийн төсөв | Хяналт хийсэн ЭМБ-ын тоо | 16 | 25 | 19 | Сүхбаатар аймагт үйл ажиллагаа явуулж байгаа 1, 2 дугаар зэрэглэлийн 8 хувийн хэвшлийн эмийн сан, УАУНЭмнэлэг, Энхлэн ачтан, Энэрэлт ачтан, Эрдэнэцагаан, Баяндэлгэр, Уулбаян, Түмэнцогт, Түвшинширээ, Халзан, Асгат, Мөнххаан сумын ЭМТөв, сумын 2 хувийн эмийн санд явцын хяналт хийн зөвлөмж чиглэл хүргүүлсэн. | 90 |
| 3 | Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө 3.5.4 | **Арга хэмжээ 4.3.1.3**: Эм эмнэлгийн хэрэгслийн хэрэгцээг оновчтой тооцон худалдан авах ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, ерөнхий гэрээгээр худалдан авч байгаа эм эмнэлгийн хэрэгслийг өөр эх сурвалжаас авахгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ | Улсын төсөв | Худалдан авсан байгууллагын тоо | 4 | 13 | 13 | 2024 оны 2-р улирлын байдлаар тендерээр 135,3 сая төгрөг, шууд гэрээ 574,6 сая төгрөг, Ерөнхий гэрээ 375 сая төгрөг, хандив тусламжаар7,6 сая төгрөг нийт 1 тэр бум 84 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авсан байна.<br><br>Ерөнхий гэрээг цахим дэлгүүрээс Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах талаар сургалтыг цахимаар нийт 8 сумын 11 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан зохион байгуулсан. | 100 |
| **Стратегийн төлөвлөгөөний зорилго 4.4: Төрийн хяналт, шалгалтыг зохион байгуулж , зөвлөгөө дэмжлэг үзүүлэх арга зүйгээр хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөрчил, дутагдал, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор хяналт шалгалтыг хэрэгжүүлэх** | | | | | | | | | |
| **Зорилт-4.4.1: Төрийн хяналт, шалгалтыг зохион байгуулах** | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Гүйцэтгэлийн зорилт-4.4.1:** | | Төрийн хяналт, шалгалтыг зохион байгуулах | УТ | Зөрчил арилгуулах хувь | 70 | 80 | 80<br><br>26.9% | ХШХ | **90** |
| | | | | Эрсдэл буурах хувь | 45 | 35 | | | |
| | | | | Өргөдөл гомдлын шийдвэрлэлт /хувь/ | 0 | 100 | | | |
| 1 | Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйл | **Арга хэмжээ-4.4.1.1:**<br>Их, дунд эрсдэлтэй объектод төлөвлөгөөт шалгалт хийнэ | УТ | Зөрчил арилгуулах хувь | 70 | 80 | 30 | Эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр: Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/11 тоот удирдамжийн хүрээнд Мөнххаан, Дарьганга, Наран, Онгон, Эрдэнэцагаан, Сүхбаатар, сумдын Эрүүл мэндийн төвүүд, төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдэж №10.1.3 кодтой Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн оношилгоо, эмчилгээний чанар, аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудсаар үнэлэхэд эрсдэлийн түвшин дунджаар 52.4 хувийн их эрсдэлтэй, үнэлэгдэж, нийт 182 заалттай 6 албан шаардлага хүргүүлж, Мөнххаан сумын Эрүүл мэндийн төвд 500000 төгрөгийн торгуулийн шийтгэвийн арга хэмжээ авч ажиллалаа. Мөн Аймгийн нэгдсэн эмнэлгийг 10.1.1 кодтой Эмнэлгийн оношилгоо, эмчилгээний чанар, аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудсаар үнэлэхэд 26,9 хувийн бага эрсдэлтэй үнэлэгдэж 10 заалттай албан шаардлага хүргүүлэв.<br><br>Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын чиглэлээр: | 100 |
| | | | | Эрсдэл буурах хувь | 45 | 35 | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/11, 03-01/01 тоот удирдамжийн хүрээнд Сүхбаатар аймгийн Дарьганга, Наран сумын эрүүл мэндийн төвүүдэд 2024 оны 03 дугаар сарын 21-23-ний өдрүүдэд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийсэн.<br><br>Хяналт шалгалтаар 84 зөрчил дутагдал илэрч 16 буюу 22.5 хувийг газар дээр нь арилгуулан, хугацаа шаардагдах 62 заалттай 3 албан шаардлага хүргүүлж, шалгалтад хамрагдсан 41 ажилчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан | |
| 2 | Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйл | **Арга хэмжээ-4.4.1.2:** Иргэн аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл гомдол, мэдээллээр төлөвлөгөөт бус шалгалт хийнэ. | | Өргөдөл гомдлоор шалгалт хийсэн тоо | 3 | Тухай бүр | I-IV Улирал | Иргэнээс 3 өргөдөл гомдол ирж, 1 гомдлыг шийдэж, 2 гомдлын шийдвэрлэх хугацаа болоогүй байна | 90 |
| 3 | Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйл | **Арга хэмжээ-4.4.1.3:** Батлагдсан удирдамжийн дагуу чиглэлийн урьдчилан сэргийлэх шалгалтыг 9 удаа зохион байгуулна. | | Шалгалт хийсэн тоо | 1 | 9 | 8 | Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан удирдамжийн дагуу 8 чиглэлээр урьдчилан сэргийлэх шалгалтыг зохион байгуулж, зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан. | 90 |
| **Нийт үнэлгээ: 90.7** | | | | | | | | | |

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: ХШҮДАХМ Д.САРАНЗАЯА

ХЯНАСАН: ДАРГА М.ДЭЛХИЙЦЭЦЭГ